



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл
болон нэр дэвшигчдээс зарцуулах зардлын дээд
хэмжээг тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, "Сонгуулийн тойрог байгуулж, мандат хуваарилах тухай" нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 65 дугаар тогтоол, Сонгуулийн ерөнхий Хорооны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 2,203.2 сая төгрөгөөр тогтоосугай.

3.Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг нийтэд мэдээлэхийг Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтэс (Д.Ичин)-т даалгасугай.


4.Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг цахим орчинд байршуулж олон нийтэд сурталчлахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Ч.Цагаанхүү)-т даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын удирдлага зохицуулалтын хэлтэс (Д.Ичин)-т даалгасугай.



М.ӨРДЭНЭЖАРГАЛ

Нийслэл дэх Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны
06 дугаар сарын 27-ны өдрийн 1/24 дугаар
тушаалын хавсралт



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд
нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ

№	Дүүрэг	Тойргийн дугаар	Нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ (сая.төг)
1	Баянгол	1	883.5
2	Баянзүрх	2	613.4
3	Баянзүрх	3	614.5
4	Баянзүрх	4	635.2
5	Сонгинохайрхан	5	642.4
6	Сонгинохайрхан	6	641.7
7	Сүхбаатар	7	650.8
8	Хан-Уул	8	897.7
9	Чингэлтэй	9	658.8
10	Багануур	10	216.9
11	Багахангай	11	99.5
12	Налайх	12	247.0